

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ  
2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

## АГУУЛГА

|  |    |
|--|----|
| НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....                                       | 1  |
| 1.1. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ .....   | 1  |
| 1.2. ХӨРВӨХ ЧАДВАР .....   | 2  |
| 1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД.....  | 2  |
| ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ .....                            | 3  |
| 2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ .....  | 3  |
| 2.1.1. Хувьцааны арилжаа .....   | 3  |
| 2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа .....  | 4  |
| 2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа .....                                  | 5  |
| 2.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа .....                                      | 5  |
| 2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ .....   | 6  |
| 2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц .....   | 6  |
| 2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА .....   | 6  |
| ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД.....                                   | 7  |
| 3.1. Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид .....                                     | 9  |
| 3.2. Мөнгөн хөрөнгийн номинал дансны тайлан .....  | 10 |
| ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН УУЛ УУРХАЙН<br>БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА.....   | 10 |
| 4.1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа .....  | 10 |
| 4.2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа .....  | 11 |
| ТАВДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ<br>ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ..... | 13 |
| 5.1. Эрх зүйн зохицуулалт.....   | 13 |
| 5.2. Тогтвортой ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх .....                              | 14 |
| <i>Хавсралт</i> .....  | 15 |


## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хөгжлийн түвшнийг үнэлж, тогтоох хүрээнд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн голлох үзүүлэлтүүд болох дараах индикаторуудыг оруулсан байдаг: зах зээлийн үнэлгээ, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хөрвөх чадвар, хувьцааны индекс.

### 1.1. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2025 оны нэгдүгээр улирлын байдлаар 12.83 их наяд төгрөгт хүрсэн нь 2024 оны жилийн эцэстэй харьцуулахад 1.51 хувиар буурсан, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.70 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд уг үзүүлэлт нь 2024 оны үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ний 16.04 хувьтай тэнцэж байна.

График 1. ДНБ-д харьцуулсан хөрөнгийн зах зээлийн үнэлгээ



Тайлбар: 2025 оны ДНБ гараагүй тул 2024 оны ДНБ-тэй харьцуулж тооцоолов.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээг бүрдүүлж байгаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 166 компаниас дараах 30 компанийн зах зээлийн үнэлгээ 11.52 их наяд төгрөгийн үнэлгээтэй байгаа нь хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээний 93.76 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 1. Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 30 компани


| №  | Компанийн нэр                             | Эзлэх хувь | №  | Компанийн нэр                | Эзлэх хувь |
|----|---|------------|----|------------------------------|------------|
| 1  | “ХААН банк” ХК                            | 20.64%     | 16 | “Лэндмн ББСБ” ХК             | 0.89%      |
| 2  | “Тавантолгой” ХК                          | 15.23%     | 17 | “Монголын хөрөнгийн бирж” ХК | 0.79%      |
| 3  | “Худалдаа хөгжлийн банк” ХК               | 9.25%      | 18 | “Монложистикс холдинг” ХК    | 0.64%      |
| 4  | “АПУ” ХК                                  | 8.66%      | 19 | “Түмэн шувуут” ХК            | 0.63%      |
| 5  | “Хас банк” ХК                             | 7.48%      | 20 | “Ард санхүүгийн нэгдэл” ХК   | 0.59%      |
| 6  | “Голомтбанк” ХК                           | 7.02%      | 21 | “Эм Жи Эл Акуа” ХК           | 0.55%      |
| 7  | “Инвескор ББСБ” ХК                        | 5.86%      | 22 | “Монгол шуудан” ХК           | 0.51%      |
| 8  | “Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК | 5.67%      | 23 | “Гутал” ХК                   | 0.46%      |
| 9  | “Төрийн банк” ХК                          | 3.17%      | 24 | “Газар шим үйлдвэр” ХК       | 0.45%      |
| 10 | “МИК холдинг” ХК                          | 2.41%      | 25 | “Техник импорт” ХК           | 0.43%      |
| 11 | “Премиум нэксус” ХК                       | 1.72%      | 26 | “Тэнгэрдаатгал” ХК           | 0.40%      |
| 12 | “Говь” ХК                                 | 1.55%      | 27 | “Мандал даатгал” ХК          | 0.37%      |
| 13 | “Сүү” ХК                                  | 1.46%      | 28 | “Шивээ-Овоо” ХК              | 0.35%      |
| 14 | “Монгол даатгал” ХК                       | 1.14%      | 29 | “Улаанбаатар бүк” ХК         | 0.35%      |
| 15 | “Улсын Их Дэлгүүр” ХК                     | 0.99%      | 30 | “Багануур” ХК                | 0.35%      |

Тайлбар: Зах зээлийн үнэлгээнд 100 хувь төрийн өмчит компанийн үнэлгээ ордоггүй болно.

## 1.2. ХӨРВӨХ ЧАДВАР

Тайлант хугацаанд хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар 2024 оны жилийн эцэстэй харьцуулахад 2.11 пунктээр , өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.64 пунктээр тус тус буурч, 0.37 хувьд хүрсэн байна. Манай улсын хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар бага байгаа нь хувьцааны хэт төвлөрөлтэй холбоотой юм. Тухайлбал 2024 оны жилийн эцсийн байдлаар ТОП-20 индексэд багтах ХК-уудын хувьцааны төвлөрлийг тооцож үзэхэд хэт төвлөрөлтэй буюу нийт хувьцааны 80.48 хувийг 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

График 2. Хөрвөх чадвар (хувиар)



## 1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД

“Монголын хөрөнгийн бирж” ХК-аас ТОП-20, MSE-A, MSE-B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцон гаргадаг. ТОП-20 индексээр зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компанийн, MSE-A болон MSE-B индексээр үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хувьцааны үнийн индексийг тус тус харуулдаг байна.

Хүснэгт 2. Индексийн үзүүлэлт

| Индекс | 2024.I    | 2024. IV  | 2025.I    | Өөрчлөлт /2024.I-2025.I/ | Өөрчлөлт /2024.IV-2025.I/ |
|--------|-----------|-----------|-----------|--------------------------|---------------------------|
| ТОП 20 | 44,693.58 | 51,296.39 | 50,171.38 | 12.26%                   | -2.19%                    |
| MSE A  | 17,799.40 | 19,795.97 | 19,422.59 | 9.12%                    | -1.89%                    |
| MSE B  | 12,207.55 | 15,197.38 | 14,729.13 | 20.66%                   | -3.08%                    |

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

ТОП-20 индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 54,018.32 нэгж, доод үзүүлэлт 49,435.11 нэгж, дундаж үзүүлэлт 51,838.99 нэгж байна. 2024 оны жилийн эцэстэй харьцуулахад 1,125.01 нэгжээр буюу 2.19 хувиар буурч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,477.80 нэгжээр буюу 12.26 хувиар өсөж **50,171.38** нэгж болсон байна.

MSE-A индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 21,103.44 нэгж, доод үзүүлэлт 19,190.38 нэгж, дундаж үзүүлэлт 20,076.70 нэгж байна. 2024 оны жилийн эцэстэй харьцуулахад 373.38 нэгжээр буюу 1.89 хувиар буурч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,623.19 нэгжээр буюу 9.12% хувиар өсөж, **19,422.59** нэгж болсон байна.

Харин MSE-B индексийн дээд үзүүлэлт 15,868.99 нэгж, доод үзүүлэлт 14,639.35 нэгж, дундаж үзүүлэлт 15,359.56 нэгж байна. 2024 оны жилийн эцэстэй харьцуулахад 468.25

нэгжээр буюу 3.08 хувиар буурч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,521.58 нэгжээр буюу 20.66% хувиар өсөж, **14,729.13** нэгж болсон байна.


## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

### 2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ

2025 оны нэгдүгээр улирлын байдлаар нийт **206.44** тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 0.74 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд өдрийн дундаж арилжаа **3.4** тэрбум төгрөг байна. Нийт арилжааны 172.53 тэрбум төгрөгийн арилжаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар, 33.91 тэрбум төгрөгийн арилжаа хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар тус тус хийгдсэн байна.

Тайлант хугацаанд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа түлхүү явагдсан бөгөөд нийт үнэт цаасны арилжааны 36.13 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, 23.88 хувийг компанийн өрийн хэрэгсэл, 23.21 хувийг хувьцаа, 16.79 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа тус тус эзэлж байна.


График 3. Үнэт цаасны арилжааны хэмжээ (бүтээгдэхүүний төрөл, хувиар)



#### 2.1.1. Хувьцааны арилжаа

График 4. Хувьцааны арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд нийт 47.91 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.7 дахин буурсан үзүүлэлт юм.



Хоёрдогч зах зээл дээрх хувьцааны арилжааг арилжаа эрхлэх байгууллага дээр бүртгэлтэй, арилжааны хэмжээгээрээ тэргүүлэгч 30 компанийн арилжааны мэдээллийг үнийн дүнгээр харуулбал:

Хүснэгт 3. Арилжааны хэмжээ хамгийн өндөр 30 компанийн арилжааны үнийн дүн (тэрбум төгрөгөөр)

| №           | Компанийн нэр                             | Үнийн дүн | №  | Компанийн нэр              | Үнийн дүн    |
|-------------|---|-----------|----|----------------------------|--------------|
| 1           | “ХААН банк” ХК                            | 8.59      | 16 | “Премиум нэксус” ХК        | 0.56         |
| 2           | “Инновэйшн инвестмент” ХК                 | 6.58      | 17 | “Түмэн шувуут” ХК          | 0.45         |
| 3           | “Инвескор ББСБ” ХК                        | 4.39      | 18 | “Төрийн банк” ХК           | 0.44         |
| 4           | “Голомтбанк” ХК                           | 3.48      | 19 | “Тэнгэрлиг медиа групп” ХК | 0.42         |
| 5           | “Дархан нэхий” ХК                         | 3.13      | 20 | “Тахько” ХК                | 0.34         |
| 6           | “Монголын хөрөнгийн бирж” ХК              | 3.05      | 21 | “Баянгол зочид буудал” ХК  | 0.30         |
| 7           | “Тавантолгой” ХК                          | 2.62      | 22 | “Сүү” ХК                   | 0.26         |
| 8           | “Хас банк” ХК                             | 2.48      | 23 | “Монложистик холдинг” ХК   | 0.23         |
| 9           | “АПУ” ХК                                  | 1.77      | 24 | “Талх чихэр” ХК            | 0.22         |
| 10          | “Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК | 1.20      | 25 | “Мандал даатгал” ХК        | 0.20         |
| 11          | “Худалдаа хөгжлийн банк” ХК               | 0.92      | 26 | “Моносхүнс” ХК             | 0.19         |
| 12          | “Лэндмн ББСБ” ХК                          | 0.89      | 27 | “Газар шим үйлдвэр” ХК     | 0.17         |
| 13          | “Ард кредит ББСБ” ХК                      | 0.71      | 28 | “Бодь даатгал” ХК          | 0.16         |
| 14          | “Ард санхүүгийн нэгдэл” ХК                | 0.62      | 29 | “Моносхүнс” ХК             | 0.12         |
| 15          | “Тэнгэр даатгал” ХК                       | 0.61      | 30 | “Гранд системс” ХК         | 0.12         |
| <b>НИЙТ</b> |   |           |    |                            | <b>45.19</b> |

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

Тайлант хугацаанд нийт 8 хувьцаат компанийн 116.2 сая ширхэг буюу 13.26 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий багцын арилжаа хийгдсэн нь нийт хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 6.42 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4. Багцын арилжаа хийгдсэн компаниуд


| №           | Үнэт цаасны нэр             | Арилжаалагдсан ширхэг (мянган ширхэг) | Үнийн дүн (тэрбум төгрөг) |
|-------------|-----------------------------|---------------------------------------|---------------------------|
| 1           | “Инновэйшн инвестмент” ХК   | 28,953.67                             | 6.31                      |
| 2           | “ХААН банк” ХК              | 395.00                                | 0.51                      |
| 3           | “Тэнгэр даатгал” ХК         | 433.71                                | 0.35                      |
| 4           | “Ард кредит ББСБ” ХК        | 3,013.83                              | 0.32                      |
| 5           | “Инвескор ББСБ” ХК          | 421.46                                | 3.40                      |
| 6           | “Тэнгэрлиг медиа групп” ХК  | 71.00                                 | 0.41                      |
| 7           | “Дархан нэхий” ХК           | 82,910.93                             | 1.64                      |
| 8           | “Худалдаа хөгжлийн банк” ХК | 10.00                                 | 0.33                      |
| <b>НИЙТ</b> |                             | <b>116,209.60</b>                     | <b>13.26</b>              |

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа

График 5. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд компанийн өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжаагаар 23.68 тэрбум төгрөгийн, хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 25.61 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.80 хувиар өссөн үзүүлэлт юм.




### 2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсанаас хойш 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 35 компани хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо 6 компанийн хувийн хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэж, улмаар тус хувийн сангууд үүсгэн байгуулагдсан байна.

График 6. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа (тэрбум төгрөгөөр)




Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлд нийт 34.36 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж өмнөх оны мөн үеэс 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

График 7. Тайлант хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжааны задаргаа

Тайлант хугацаанд хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн нийт 34.36 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэнээс биржээр арилжаалагддаг хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангаар 0.75 тэрбум төгрөгийн арилжаа, хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар 33.91 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь тус тус нийт арилжааны 2.16 болон 97.84 хувийг бүрдүүлж байна. Хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн нийт хоёрдогч зах зээлийн арилжааны 38.22

хувийг буюу 12.96 тэрбумын арилжаа нь нэгж эрхээ эргүүлэн худалдан авах арилжаа байна.




- Хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сан
- Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан, ETF

### 2.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

График 8. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаагаар 25.00 тэрбум төгрөгийн арилжаа, хоёрдогч зах зээлд нийт 49.58 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, нийт 74.58 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 4.46 дахин өссөн үзүүлэлт юм.




## 2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ

Тайлант хугацаанд 7,502 шинэ данс, 10,542 холболтын данс шинээр нээгдэж өссөн дүнгээр нийт 2,605,566 данс, 682,502 холболтын данс “ҮЦТХТ” ХХК-д бүртгэлтэй байна.

### 2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц

График 9. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны үнийн дүнд эзлэх хувь

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нийт хоёрдогч зах зээлийн арилжаанд дотоодын иргэний хийсэн арилжаа 34.22 тэрбум төгрөг (40.99 хувь), дотоодын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 46.21 тэрбум төгрөг (55.36 хувь), гадаадын иргэний хийсэн арилжаа 0.82 тэрбум төгрөг (0.98 хувь), гадаадын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 2.23 тэрбум төгрөг (2.68 хувь)-ийг тус тус эзэлж нийт 83.48 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.



Эх сурвалж: "МУЦКТ" ХХК

Дээрх арилжаанд давтагдсан тоогоор нийт 33,528 хүн, 570 аж ахуйн нэгж оролцож, 34,098 удаагийн арилжаа хийсэн байна. (Дэлгэрэнгүйг доорх хүснэгтээс харна уу.)

Хүснэгт 5. Хөрөнгө оруулагчдын бүтэц (давтагдсан тоо, хувиар)

|                | Арилжаанд оролцогчийн тоо |             | Арилжаанд оролцсон тоо |             |
|----------------|---------------------------|-------------|------------------------|-------------|
|                | Тоо                       | Хувь        | Тоо                    | Хувь        |
| Гадаадын ААН   | 53                        | 0.16%       | 319                    | 0.36%       |
| Гадаадын иргэн | 214                       | 0.63%       | 748                    | 0.85%       |
| Дотоодын ААН   | 517                       | 1.52%       | 3,423                  | 3.88%       |
| Дотоодын иргэн | 33,314                    | 97.70%      | 83,754                 | 94.91%      |
| <b>Нийт</b>    | <b>34,098</b>             | <b>100%</b> | <b>88,244</b>          | <b>100%</b> |

Эх сурвалж: "МУЦКТ" ХХК


## 2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс буюу 2021 оны 09 дүгээр сараас 2025 оны нэгдүгээр улирал хүртэлх хугацаанд биржийн бус зах зээлд нийт 154 компанийн нийт 4.4 их наяд төгрөг, 208.3 сая ам.долларын үнийн дүн бүхий 304 өрийн хэрэгсэл бүртгэгдсэн бөгөөд 3.7 их наяд төгрөг, 160.3 сая ам.долларыг бодит татан төвлөрүүлсэн.

Үүнээс тайлант хугацаанд 23 компанийн нийт 189.3 тэрбум төгрөг, 30.0 сая ам долларын үнийн дүн бүхий 24 өрийн хэрэгсэл гарсан бөгөөд 240.57 тэрбум төгрөг, 31.59 сая ам.долларыг бодит татан төвлөрүүлсэн


Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүргэгдсэн үнийн дүн 6.36 хувиар, бодит татан төвлөрүүлсэн дүн 15.96 хувиар өссөн үзүүлэлт юм.

График 10. Тайлант хугацаанд ББЗЗ-д бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийн дүн болон бодит татан төвлөрүүлсэн дүн



Тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар нь ангилбал банк бус 53.8 хувь, барьцаалан зээлдүүлэх 5.5 хувь, хөрөнгө оруулалтын компани 1.3 хувь, барилга 12.1 хувь, уул уурхай 11.4 хувь, худалдаа үйлчилгээ 13.2 хувь, үйлдвэрлэл 1.3 хувь, мэдээлэл холбоо 1.3 хувь, бусад салбар 1.0 хувийг тус тус бүрдүүлж байна.

График 11. Тайлант хугацаанд ББЗЗ-д бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийн дүнг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар (хувиар)



## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

Өнөөдрийн байдлаар үнэт цаасны зах зээл дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Инновацийн тухай хууль зэрэг хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр хууль болон бусад холбогдох дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлж байна.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй 311 зохицуулалттай этгээд байна.

Хүснэгт 6. Үнэт цаасны зах зээлд оролцогчид

| №  | Үйл ажиллагааны төрөл   | Тоо             |
|--|---|-----------------|
| <b>Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгч</b>   |   |                 |
| 1  | Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага  | 3               |
| 2  | Үнэт цаасны клирингийн байгууллага  | 2 <sup>1</sup>  |
| 3  | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага  | 1               |
| 4  | Үнэт цаасны төлбөрийн байгууллага   | 1 <sup>2</sup>  |
| 5  | Хөрөнгө оруулалтын менежментийн компани   | 35              |
| 6  | Хамтын хөрөнгө оруулалтын сан /хаалттай, нээлттэй/  | 6               |
| 7  | Кастодиан банк  | 3               |
| 8  | Үнэт цаасны компани   | 54              |
|  | Брокер  | 53              |
|  | Үүнээс:   |                 |
|  | Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэгч                | 17              |
|  | Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээний үйлчилгээ үзүүлэгч | 21              |
|  | Дилер   | 34              |
|  | Андеррайтер   | 26 <sup>3</sup> |
|  | Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэгч  | 21 <sup>4</sup> |
| 9  | Хөрөнгө итгэмжлэн удирдагч  | 8               |
| 10   | Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч   | 1               |
| 11   | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөлтэй компани   | 65 <sup>5</sup> |
| 12   | ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага   | 1               |
| 13   | ХАА-н биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага                                      | 9               |
| 14   | Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага   | 1 <sup>6</sup>  |
| 15   | Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч /брокер/  | 13 <sup>7</sup> |
| 16   | Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллага   | 3               |
| <b>Бүртгэлтэй хөндлөнгийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд</b>                              |   |                 |
| 17   | ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэгч байгууллага   | 72 <sup>8</sup> |
|  | Аудитын үйлчилгээ үзүүлэгч байгууллага  | 54              |
|  | Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч байгууллага   | 25              |
| 18   | ҮЦЗЗ-д оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч байгууллага  | 44              |
| <b>Нийт (Тусгай зөвшөөрөл болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын тоо)</b> |   | <b>311</b>      |

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 166 ХК байна. Мөн Хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 273 дугаар тогтоолоор “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ГҮТББ-ыг, 2015 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 379 дүгээр тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийг өөрийгөө зохицуулах байгууллагаар тус тус бүртгэсэн.

<sup>1</sup> Тус тоонд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болох “Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК болон “МУЦКТ” ХХК орсон болно.

<sup>2</sup> “ҮЦТХТ” ХХК нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон төлбөрийн үйл ажиллагааг үзүүлдэг.

<sup>3</sup> Тус тоонд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 банк /“Голомт банк” ХК, “Тээвэр Хөгжлийн банк” ХХК/ орсон болно.

<sup>4</sup> Тус тоонд хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх 1 хөрөнгө оруулалтын менежментийн компани /“Блак свон” ХХК/

<sup>5</sup> Тус тоонд “МИК ОССК” ХХК-37, “УЦСК” ХХК-5, “Носк тав ТЗК” ХХК-5, нээлттэй хүрээнд ХБҮЦ гаргасан 17 ТЗК, хаалттай хүрээнд гаргасан 1 ТЗК тус тус орсон.

<sup>6</sup> Тус тоонд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болох “Монголын хөрөнгийн бирж” ХК орсон болно.

<sup>7</sup> Нэр бүхий 9 үнэт цаасны компани тус үйл ажиллагааг давхар эрхлэн гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг авсан.

<sup>8</sup> ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэх үйлчилгээг зэрэг үзүүлдэг 7 компани байна.

Хүснэгт 7. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй ХК-ийн тоо болон зах зээлийн үнэлгээ

| Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын нэр  | Бүртгэлтэй ХК-ийн тоо | Зах зээлийн үнэлгээ 2024   |
|--|-----------------------|--|
| 1) “Монголын хөрөнгийн бирж” ХК<br>-100 хувь төрийн өмчит<br>-Төрийн өмчийн оролцоотой<br>-Бусад | 164<br>3<br>11<br>150 | 12,807,305,917,844.10 ₮<br>(Тус биржийн зах зээлийн үнэлгээнд 100 хувь төрийн өмчит компанийн үнэлгээ ордоггүй болно.) |
| 2) “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХК   | 2                     | 19,073,869,512.00 ₮  |
| 3) “Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК  | -                     | -  |

### 3.1. Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид

2025 оны нэгдүгээр улирлын байдлаар Хороонд бүртгэлтэй 54 үнэт цаасны компани байгаагаас үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон бусад хавсран эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй 53 үнэт цаасны компани байна. Үүнээс тайлант хугацаанд тайлан ирүүлсэн 52 үнэт цаасны компанийн нийт хөрөнгө 300.1 тэрбум, нийт орлого 7.0 тэрбум төгрөг байна. Тус компаниудыг нийт хөрөнгийн хэмжээ болон нийт орлогын хэмжээгээр нь ангилан үзвэл дараах бүтэцтэй байна.

Хүснэгт 8. Үнэт цаасны компаниудын хөрөнгийн болон орлогын шатлалын бүтэц

| Нийт хөрөнгө                  | Үнэт цаасны компаниудын тоо | Нийт орлого                   | Үнэт цаасны компаниудын тоо |
|-------------------------------|-----------------------------|-------------------------------|-----------------------------|
| 0 – 100,000,000               | 4                           | 0– 100,000,000                | 44                          |
| 100,000,001 - 1,000,000,000   | 23                          | 100,000,001 - 1,000,000,000   | 5                           |
| 1,000,000,001 ба түүнээс дээш | 25                          | 1,000,000,001 ба түүнээс дээш | 3                           |

2025 оны нэгдүгээр улирлын байдлаар Хороонд бүртгэлтэй 35 хөрөнгө оруулалтын менежментийн компани байна. Тус компаниудын хувьд 42 хувийн хөрөнгө оруулалтын сан, 6 хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр удирдан ажиллаж байна. Үүнээс тайлант хугацаанд тайлан ирүүлсэн 34 хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын нийт хөрөнгө 155.0 тэрбум, нийт орлого 15.9 тэрбум төгрөг байна. Тус компаниудыг нийт хөрөнгийн хэмжээ болон нийт орлогын хэмжээгээр нь ангилан үзвэл дараах бүтэцтэй байна.

Хүснэгт 9. Хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын хөрөнгийн болон орлогын шатлалын бүтэц

| Нийт хөрөнгө                  | Хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын тоо | Нийт орлого                   | Хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын тоо |
|-------------------------------|---|-------------------------------|---|
| 0 – 100,000,000               | 9   | 0 – 100,000,000               | 31  |
| 100,000,001 - 1,000,000,000   | 16  | 100,000,001 - 1,000,000,000   | 2   |
| 1,000,000,001 ба түүнээс дээш | 9   | 1,000,000,001 ба түүнээс дээш | 1   |

2025 оны нэгдүгээр улирлын байдлаар Хороонд бүртгэлтэй 6 хамтын хөрөнгө оруулалтын сан байгаагаас 3 нь хамтын нээлттэй, 2 нь хамтын хаалттай, 1 хамтын хаалттай биржээр арилжаалагдах сан хэлбэртэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна. Хөрөнгө

оруулалтын сангуудын нийт хөрөнгө 145.41 тэрбум, нийт орлого 5.85 тэрбум төгрөг байна. Тус компаниудыг нийт хөрөнгийн хэмжээ болон нийт орлогын хэмжээгээр нь ангилан үзвэл дараах бүтэцтэй байна.

Хүснэгт 10. Хамтын хөрөнгө оруулалтын сангуудын хөрөнгийн болон орлогын шатлалын бүтэц

| Нийт хөрөнгө                  | Хамтын хөрөнгө оруулалтын сангуудын тоо | Нийт орлого                   | Хамтын хөрөнгө оруулалтын сангуудын тоо |
|-------------------------------|---|-------------------------------|---|
| 0 – 100,000,000               | 0                                       | 0 – 100,000,000               | 4                                       |
| 100,000,001 - 1,000,000,000   | 2                                       | 100,000,001 - 1,000,000,000   | 0                                       |
| 1,000,000,001 ба түүнээс дээш | 4                                       | 1,000,000,001 ба түүнээс дээш | 2                                       |

### 3.2. Мөнгөн хөрөнгийн номинал дансны тайлан


2025 оны нэгдүгээр улирлын байдлаар Хороонд бүртгэлтэй номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээний үйлчилгээ үзүүлэгч 21 компани байна. Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс мөнгөн хөрөнгийн номинал дансны тайланг цахимаар хүлээн авахтай холбоотойгоор холбогдох ажлыг хийж гүйцэтгэснээр энэ оны эхний улирлаас компаниуд тайлангаа цахимаар ирүүлэх боломжтой болсон бөгөөд тайлант хугацаанд нийт 18 компани тайлангаа ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд дээрх 18 компанид бүртгэлтэй нийт 1,433,118 харилцагч байгаагаас 29,991 харилцагч үйлчилгээ авч, 325.7 тэрбум төгрөгийн болон 29.4 сая ам.долларын гүйлгээ хийсэн бөгөөд *Хавсралт*-аас дэлгэрэнгүй тайланг үзнэ үү.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА

### 4.1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

График 12. ХААБ-ээр арилжаалагдсан түүхий эдийн арилжаа (тэрбум төгрөгөөр)



Тайлант хугацаанд Хөдөө аж ахуйн бирж нь 31 удаагийн цахим арилжаа зохион байгуулан 101 хэлцлээр нийт 53.33 тэрбум төгрөгийн үнэ бүхий бараа, түүхий эдийн арилжаа хийсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 6.18 тэрбум төгрөгөөр буюу 10.38 хувиар буурсан үзүүлэлт юм.

ХААБ-ээр дараах төрлийн бүтээгдэхүүнүүд арилжаалагдсан байна. Үүнд:


Зураг 1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа



Хүснэгт 11. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны дүн (бүтээгдэхүүний төрлөөр)

|                      |                       |   |
|----------------------|-----------------------|---|
| Ямааны ноолуур       | 17,239,616,000        | Нийт арилжааны дийлэнх хувийг буюу 32.33 хувийг ямааны ноолуур, 49.20 хувийг ямааны завод ноос, 1.97 хувийг хонины ноос, 1.54 хувийг тэмээний ноос, 14.96 хувийг тосны ургамал тус тус эзэлж байна. |
| Хонины ноос          | 1,050,550,000         |   |
| Ямааны завод ноос    | 26,238,961,000        |   |
| Тэмээний ноос        | 820,840,000           |   |
| Тосны ургамал (рапс) | 7,979,050,000         |   |
| <b>Нийт</b>          | <b>53,329,017,000</b> |   |

График 14. Нийт арилжаалагдсан хөдөө аж ахуйн биржийн арилжааны бүтэц (үнийн дүнд эзлэх хувиар)




2025 оны нэгдүгээр улирлын байдлаар хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий нэр бүхий 9 хуулийн этгээд байна. Үүнээс тайлант хугацаанд 53.33 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсний 14.77 хувийг “Алтан шагай импекс” ХХК, 18.87 хувийг “Хаан Тэлмэн” ХХК, 56.20 хувийг “Ханбүргэд Хэнтий” ХХК, 10.17 хувийг “Цэц инвест” ХХК тус тус бүрдүүлж байна.

#### 4.2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа

2025 оны нэгдүгээр улиралд нийт 24 удаагийн арилжаагаар 0.68 сая тонн нүүрсийг 193.05 тэрбум төгрөгөөр, 65 удаагийн арилжаагаар 2.07 сая тонн төмрийн хүдэр, баяжмалыг 431.07 тэрбум төгрөгөөр, 4 удаагийн арилжаагаар 11,635 тонн хайлуур жоншийг 10.24 тэрбум төгрөгөөр, 1 удаагийн арилжаагаар 5,000 тонн зэсийн баяжмалыг 33.05 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалж, нийт 94 удаагийн арилжаагаар 2.77 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 667.40 тэрбум төгрөгөөр арилжаалсан ба өдрийн дундаж арилжаа 11.12 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт арилжаалагдсан бүтээгдэхүүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад биет хэмжээгээр 2.02 дахин, мөнгөн дүнгээр 3.73 дахин тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Тухайлбал өмнөх оны мөн үед нийт 127 удаагийн арилжаагаар 5.58 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 2.49 их наяд төгрөгөөр арилжаалсан байна.


График 15. Нийт арилжаалагдсан нүүрсний хэмжээ (төрөл, ангилал, хувиар)



Тайлант хугацаанд нийт 5 төрлийн 0.68 сая тонн нүүрс арилжаалагдсанаас 1/3 коксжих нүүрс 28.30 хувийг, баяжуулсан коксжих нүүрс 37.74 хувийг, баяжуулсан коксжих чанаргүй нүүрс 20.75 хувийг, баяжуулсан сул коксжих нүүрс 7.55 хувийг, чийг багатай хүрэн нүүрс 5.66 хувийг тус тус эзэлж байна.

График 16. Нийт арилжаалагдсан төмрийн хэмжээ (төрөл, ангилал, хувиар)

Тайлант хугацаанд нийт 2.07 сая тонн төмрийн хүдэр, баяжмал арилжаалагдсанаас 14.81 хувийг Fe-52%-ийн агууламжтай төмрийн хүдэр, 79.46 хувь Fe-58%-ийн агууламжтай төмрийн баяжмал, 5.73 хувийг Fe-65%-ийн агууламжтай төмрийн баяжмал тус тус бүрдүүлж байна.



Манай улсын хувьд 2025 оны нэгдүгээр улирлын байдлаар нийт 17.53 сая тонн нүүрс болон 1.77 сая тонн төмрийн хүдэр, баяжмал, 0.40 сая тонн жоншны хүдэр, баяжмал, 0.46 сая тонн зэсийн хүдэр, баяжмалыг тус тус экспортолсон байна. Үүнээс нүүрсний экспортын 3.87 хувь, жоншны хүдэр, баяжмалын 2.88 хувь, зэсийн хүдэр, баяжмалын 1.10 хувийг тус тус уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалсан байна. Харин уул уурхайн биржээр арилжаалсан төмрийн хүдэр, баяжмал нь нийт экспортын дүнгээс 17.26 хувиар их байна. Энэ нь уул уурхайн биржээр арилжаалсан бараа бүтээгдэхүүний экспортод гаргах хугацаа арилжааны өдрөөс зөрүүтэй байдгаас шалгаалсан байна.

Хүснэгт 12. УУББ-ээр дамжсан уул уурхайн бүтээгдэхүүний экспортын дүнд эзлэх хувь

| Экспортын хэмжээ бүтээгдэхүүний төрлөөр | Нийт экспорт /сая, тонн/ | УУББ-ээр арилжаасан /сая, тонн/ | Эзлэх хувь |
|---|--------------------------|---------------------------------|------------|
| Нүүрс                                   | 17.53                    | 0.68                            | 3.87%      |
| Төмрийн хүдэр, баяжмал                  | 1.77                     | 2.07                            | 100.00%    |
| Жоншны хүдэр, баяжмал                   | 0.40                     | 0.01                            | 2.88%      |
| Зэсийн хүдэр, баяжмал                   | 0.46                     | 0.01                            | 1.10%      |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

## ТАВДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2025 оны нэгдүгээр улирлын байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, тогтвортой ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлэх чиглэлд голчлон анхаарч дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

### 5.1. Эрх зүйн зохицуулалт

УИХ-аас Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталсан.

Хууль батлагдсантай холбоотойгоор Хорооны зүгээс шинээр болон нэмэлт, өөрчлөлт оруулахаар зохицуулсан холбогдох дүрэм, журмын төслийг боловсруулан шат дараатай батлуулан ажиллаж байна.



#### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Тухайлбал, Хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор “Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны журам”-ыг баталж, гарааны компани болон жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн хөрөнгийн зах зээлд оролцох оролцоог хангах, бизнесийн орчныг дэмжих, харьцангуй найдвартай, хямд санхүүжилтийн эх үүсвэрийг богино хугацаанд, бага зардлаар татан төвлөрүүлэх зохицуулалтын орчин бүрдүүлээ.

Түүнчлэн, хөрөнгө оруулагчдын хувьд санхүүжилт татан төвлөрүүлж буй компанийн хувьцаа эзэмшигч болох, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох, өгөөж хүртэх боломжтой болж, хөрөнгө оруулалтын сагсаа төрөлжүүлэх боломж нэмэгдэж байгаа юм.

Мөн мөнгөний зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ болох банкнаас гаргах хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжихтай холбоотой эрх зүйн зохицуулалтын орчин бий болсонтой холбогдуулан Хорооны 2025 оны 07 дугаар тогтоолоор “Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнах журам”-ыг баталж, нарийвчилсан зохицуулалтын орчныг бүрдүүлээ.

Үнэт цаасны зах зээлд хадгаламжийн сертификат арилжаалагдаж эхэлснээр хөрөнгийн зах зээл дээр арилжаалагддаг, хөрвөх чадвар сайтай хадгаламжийн сертификат бий болж, банкны салбараас эх үүсвэр татагдах эрсдэл буурч, иргэд, хадгаламж эзэмшигчид цаг хугацаа, орон зайнаас үл хамааран банкаа сонгон хадгаламжид хөрөнгө оруулж, хадгаламжаа хоёрдогч зах дээр арилжаалах боломжтой болох юм.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хамтын хөрөнгө оруулалтын сангийн төрөл, сангийн хөрөнгө оруулалт хийх активын төрөл нэмэгдсэнээс гадна хувийн хөрөнгө оруулалтын санг гэрээний үндсэн дээр үүсгэн байгуулах зохицуулалтын орчин бүрдсэн.

Энэ хүрээнд гэрээний үндсэн дээр үүсгэн байгуулах хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, гэрээнд тавих шаардлагыг тогтоохтой холбогдох харилцааг зохицуулахаар “Гэрээний үндсэн дээр үүсгэн байгуулах

хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ыг боловсруулж, Хорооны 2025 оны 64 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан бөгөөд тус журам батлагдсанаар дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагчдын суурь сайжирч, тэдгээрийн хөрөнгийн зах зээлд оролцох оролцоо өсөж, дотоодын үнэт цаасны арилжаа, зах зээлийн үнэлгээ нэмэгдэн хөрөнгийн зах зээлийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх чухал ач холбогдолтой.

Үүний сацуу Хорооны зүгээс санхүүгийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиг үүргийн хүрээнд хүний эрхийг дээдэлсэн хүн төвтэй, хуулийн үзэл баримтлалд тулгуурласан эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, хууль тогтоомжийг тодорхой ойлгомжтой болгож, хууль хүн бүрд ижил тэгш үйлчилдэг болгох, нийгмийн хурдацтай хөгжлийн шаардлагад нийцүүлэн эрх зүйн зохицуулалтыг цаг алдалгүй ажилладаг болгох зэрэг чиглэлийг баримтлан ажиллаж, холбогдох дүрэм, журмуудыг хүчингүй болгон захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангаас хасуулах, шинээр батлах ажиллагааг хэрэгжүүллээ.

Тухайлбал, Хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”, 2022 оны 275 дугаар тогтоолоор баталсан ““Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”, 276 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ыг тус тус хүчингүй болгохоор

шийдвэрлэж, Хорооны 2025 оны 60 дугаар тогтоолоор “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”, 64 дүгээр тогтоолоор “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагааны журам”, “Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”, “Гэрээний үндсэн дээр үүсгэн байгуулах хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам”-ыг тус тус баталсан.

## **5.2. Тогтвортой ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх**

Олон улсад тогтвортой, ногоон хөгжил рүү шилжих шинэ хандлагыг даган компаниуд зөвхөн хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг бий болгоход бус урт хугацааны үнэ цэн, тогтвортой өсөлтийг чухалчлах болсон нь тогтвортой байдлын хүчин зүйлс нь санхүүгийн шийдвэр гаргах чухал бүрэлдэхүүн хэсэг болсныг харуулж байна. Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс тогтвортой ногоон санхүүжилтийг тогтолцоог бий болгоход онцгой анхаарч ажиллаж байна.

Тухайлбал, Испанийн засгийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Үндэсний Санхүүжилтийн Нэгдсэн Тогтолцоо (INFF)-оос хамтран “Түншүүд хоорондын уулзалт”-ын хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулагдсан “Тогтвортой хөгжлийн зорилт ба сэдэвчилсэн бонд” сэдэвт хэлэлцүүлэгт Хорооны төлөөлөл оролцож, ногоон, тогтвортой санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн стратегиуд болон ногоон бонд, тогтвортой хөгжлийн зорилтуудтай холбоотой санаачилгуудаа танилцууллаа.

## Хавсралт

Хүснэгт 1. Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээ үзүүлэгчдийн тайлан

| №    | Компанийн нэр                             | Нийт харилцагчдын тоо |              | Үйлчилгээ авсан харилцагчдын тоо | Нийт авсан/ зарсан гүйлгээ | Эцсийн үлдэгдэл   |
|------|---|-----------------------|--------------|----------------------------------|----------------------------|-------------------|
|      |   | ₮                     |              |                                  |                            |                   |
| 1    | “Бидисек ҮЦК” ХК                          | ₮                     | 6,199        | 1,345.00                         | 27,839,552,751.26          | 2,103,797,013.34  |
|      |   | \$                    | 62           | 4                                | 1,343,642.10               | 1701.45           |
| 2    | “Ард секьюритиз ҮЦК” ХХК                  |                       | 166,124      | 5,971                            | 15,612,299,923.21          | 381,573,985.63    |
| 3    | "Гүүдсек ҮЦК" ХХК                         | ₮                     | 753,871      | 651                              | 1,487,735,523.19           | 138,768,262.27    |
|      |   | \$                    | 20           |                                  |                            | 10.7              |
| 4    | “Райнос инвестмент ҮЦК” ХХК               | ₮                     | 8,867        | 196                              | 13,800,818,341.08          | 247,253,202.78    |
|      |   | \$                    | 77           | 40                               | 3,295,440.01               | 74,620.21         |
| 5    | “Эс Жи Капитал ҮЦК” ХХК                   |                       | 6,076        | 8                                | 84,364,777.49              | 45,778.23         |
| 6    | “ТИ ДИ БИ СЕКЬЮРИТИС ҮЦК” ХХК             |                       | 56,373       | 1,244                            | 8,738,402,342.02           | 1,672,726,219.96  |
| 7    | “Голомт капитал ҮЦК” ХХК                  | ₮                     | 78,251       | 8,768                            | 78,243,689,182.00          | 3,657,058,873.00  |
|      |   | \$                    | 28           | 2                                | 1,892,812.22               | 9,999.57          |
| 8    | “Өлзий энд КО капитал ҮЦК” ХХК            |                       | 44,775       | 668                              | 4,193,097,423.99           | 601,788,084.90    |
| 9    | “Апекс капитал ҮЦК” ХХК                   |                       | 36,842       | 3,370                            | 40,767,973,266.49          | 1,237,215,831.07  |
| 10   | “Инвескор капитал ҮЦК” ХХК                | ₮                     | 12,321       | 521                              | 71,942,267,523.12          | 1,746,848,489.42  |
|      |   | \$                    | 13           | 4                                | 102,604.61                 | 18,424.63         |
| 11   | “Нэйшнлсекьюритис ҮЦК” ХХК                |                       | 129,339      | 26                               | 18,063,601.18              | 2,518,588.83      |
| 12   | “Таван богд капитал ҮЦК” ХХК              | ₮                     | 60,924       | 2,612                            | 9,383,236,725.10           | 275,409,435.90    |
|      |   | \$                    | 798          | 314                              | 22,724,753.99              | 1,485,283.43      |
| 13   | "Мандал капитал маркетс ҮЦК" ХХК          |                       | 18,636       | 3,634                            | 34,891,815,328.77          | 667,539,234.23    |
| 14   | "Новел-Инвестмент ҮЦК" ХХК                |                       | 34,190       | 65                               | 1,313,094,258.11           | 140,659,079.21    |
| 15   | “Эс Жи инвестмент энд секьюритис ҮЦК” ХХК |                       | 8,517        | 326                              | 192,440,588.57             | 31,355,510.84     |
| 16   | “Стандарт-Инвестмент ҮЦК” ХХК             |                       | 1,019        | 172                              | 12,924,132,726.06          | 3,217,355,657.97  |
| 17   | “Тэнгэр капитал ҮЦК” ХХК                  |                       | 9,759        | 33                               | 4,231,613,952.39           | 5,752,852.33      |
| 18   | “Монсек ҮЦК” ХХК                          |                       | 37           | 17                               | 73,808,892.14              | 8,567,581.18      |
| НИЙТ | Төгрөг                                    |                       | 1,432,120.00 | 29,627.00                        | 325,738,407,126.17         | 16,136,233,681.09 |
|      | Ам.доллар                                 |                       | 998.00       | 364.00                           | 29,359,252.93              | 1,590,039.99      |